



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А226

Алтай хот

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалт, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, Үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 314 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААОНӨГ/202312001 дугаартай Төгрөг сумд усны машин нийлүүлэх ажлыг гэрээ шууд байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Төгрөг сумын Засаг дарга (Б.Чимэгбаяр)-д олгосугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Төгрөг сумын Засаг дарга (Б.Чимэгбаяр)-д үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-г тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ